

# Land Acquisition and Resettlement Plan

---

Project Number: 42184-027  
July 2018

## Proposed Loan for Additional Financing Mongolia: Southeast Gobi Urban and Border Town Development Project

This is the Mongolia translation of the English land acquisition and resettlement plan. Should there be any difference between the Mongolian and English versions, the English version will prevail.

Prepared by Ministry of Construction and Urban Development for the Asian Development Bank.

## **CURRENCY EQUIVALENTS**

(as of 20 July 2018)

Currency Unit	–	togrog (MNT)
MNT1.00	=	\$0.000406
\$1.00	=	MNT2,463.00

## **ABBREVIATIONS**

ADB	–	Asian Development Bank
AP	–	affected person/people
LAR	–	land acquisition and resettlement
LARP	–	land acquisition and resettlement plan
LACUDD	–	Land Affairs, Construction and Urban Development Department
PUSO	–	public utility service organization

## **NOTE**

In this report, "\$" refers to United States dollars.

This land acquisition and resettlement plan is a document of the borrower. The views expressed herein do not necessarily represent those of ADB's Board of Directors, Management, or staff, and may be preliminary in nature. Your attention is directed to the "terms of use" section of this website.

In preparing any country program or strategy, financing any project, or by making any designation of or reference to a particular territory or geographic area in this document, the Asian Development Bank does not intend to make any judgments as to the legal or other status of any territory or area.



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Sangay Penjor  
Director  
Urban and Social Sectors Division  
East Asia Department  
Asian Development Bank  
Manila, Philippines

23119 Чингис хот, Хэнтий аймаг  
Утас / факс: 70-56-21-51  
Э-шуудан: infozdtg@khentii.gov.mn

23rd July, 2018 № 9/1275  
танай -ы № -т

Subject: Endorsement Letter

Reference: MON Second Additional Financing for Southeast Gobi Urban and Border Town Development Project - Land Acquisition and Resettlement Plan

We would like to submit the Land Acquisition and Resettlement Plan (July 2018) (LARP) for the Second Additional Financing for Southeast Gobi Urban and Border Town Development Project. (Project)

The LARP has been prepared in accordance with ADB's Safeguard Policy Statement (2009) (SPS) and applicable Mongolian laws and regulations.

We hereby confirm the content of the LARP and makes commitment that it will be implemented and budget for land acquisition and resettlement will be allocated on time.

Best Regards,





Г АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ  
ЗҮҮН АЗИЙН ГАЗРЫН ХОТ БАЙГУУЛАЛТ,  
НИЙГМИЙН САЛБАРЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА САГАЯ ПЕНЖОР ТАНАА

МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

23119 Чингис хот, Хэнтий аймаг  
Утас / факс: 70-56-21-51  
Э-шуудан: infozdtg@khentii.gov.mn

2018. 07.23 № 9/1275  
таний -ы № -т

Г Баталгаа хүргүүлэх тухай

Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн Нэмэлтийн нэмэлт санхүүжилтийн бэлтгэл төслийн Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг /2018 оны 07 дугаар сар/ хүргүүлж байна.

Энэхүү төлөвлөгөөг Азийн хөгжлийн банкны Нийгмийн хамгааллын бодлогын баримт бичиг /2009/ болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн болно.

Бид Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний агуулгыг үүгээр баталгаажуулж байгаа бөгөөд төлөвлөгөөг хэрэгжүүлэн нөхөн олговрыг хугацаанд нь олгох болно.

Хавсралт 4 хуудастай

ХҮНДЭТГЭСЭН,

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ

Ц.ЧОГСОМЖАВ



# **Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө**

**SC 109894 MON: Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоох суурин газруудын хөгжлийн төслийн Нэмэлтийн нэмэлт санхүүжилтийн бэлтгэл төсөл**

# АГУУЛГА

I.	Төслийн үндэслэл	4
II.	Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд ба ГЧНШ-ийн нөлөөллийн цар хүрээ	5
A.	Булган аймаг	5
B.	Дундговь аймаг	6
C.	Хэнтий аймаг	8
D.	Хөвсгөл аймаг	10
E.	Сүхбаатар аймаг	12
III.	Хууль, Бодлогын хамрах хүрээ, Авах туслалцаа	13
IV.	Гомдол барагдуулах механизм	14
V.	Хэрэгжүүлэх арга зам	15
VI.	Хэрэгжилтийн хуваарь ба Мониторинг	15
VII.	ГЧНШТ-ний өртгийн үнэлгээ	16
	Хавсралт 1: Булган аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн албан тоот .....	17
	Хавсралт 2: Дундговь аймгийн ГХБХБГ-ын албан тоот .....	20
	Хавсралт 3: Хэнтий аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн тоот.....	22
	Хавсралт 4: Хэнтийн аймгийн Засаг даргын газар олгосон захирамж.....	23
	Хавсралт 5: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ЗД-ын захирамж .....	31
	Хавсралт 6: Сүхбаатар аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн тоо .....	34
	Хавсралт 7: Гомдол гаргах маягт .....	36
	Хавсралт 8: ГЧНШТ-ний төлөвлөлтийн үед хийгдсэн уулзалтууд.....	37
	Хавсралт 9: Газар чөлөөлөлтийн тухай товхимол .....	39

## **Товчлол**

АХБ	Азийн хөгжлийн банк
НӨИ	Нөлөөлөлд өртсөн иргэн
ГЧНШ	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт
ГЧНШТ	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
НААУБ	Нийтийн аж ахуй, үйлчилгээний байгууллага
ЗӨГХБХОСГХТ	Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн орчмын суурин газруудын хөгжлийн төсөл
НХББ	Нийгмийн хамгааллын бодлогын баримт бичиг
ТУН	Төсөл удирдах нэгж

## I. Төслийн үндэслэл

1. Төлөвлөгдж буй төсөл нь одоо хэрэгжиж буй Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл (ӨДАХБХОСГХТ: G0204 төсөл) болон түүний эхний нэмэлт санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх, цаашдын дэмжлэг туслалцааны удирдлага, нэмэлт санхүүжилтийн хоёр дахь төсөл юм. Одоогийн Тэтгэлэг, Зээлийн<sup>1</sup> санхүүжилтийн хоёр дахь нэмэлт санхүүжилт нь юуны өмнө чухал ач холбогдол бүхий, хурдацтай хөгжиж буй 5 аймгийн төвүүдийн бохир усны менежментийн чанар, найдвартай байдлыг сайжруулах замаар төслийн нийгэм эдийн засгийн үр ашгийг өргөжүүлэх, өсгөн нэмэгдүүлэх болно. Хоёр дахь нэмэлт төслийг Булган, Дундговь, Хэнтий, Хөвсгөл болон Сүхбаатар аймгуудад хэрэгжүүлнэ. Үүнээс гадна, нэмэлт санхүүжилт нь одоогийн<sup>2</sup> төсөл хэрэгжиж байгаа аймгууд болон шинээр төсөл хэрэгжих аймгуудын нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бохир усны менежментийн чадварыг сайжруулахад техникийн туслалцаа үзүүлэх замаар тогтолцооны тогтвортой байдлыг бэхжүүлэх юм.

2. **Төслийн аймгийн төвүүдийн бохир усны менежментийн өнөөгийн байдал.** Төслийн бүх аймгийн төв хэсэгт үйлчилгээ үзүүлдэг бохир усны шугам сүлжээтэй. НААУБ<sup>3</sup>-ын мэдээллээр бохир усны шугам сүлжээ нь харьцангуй сүүлд баригдсан, сайн нөхцөлтэй, солих шаардлагагүй гэж байсан. Түүнчлэн, одоогийн болон богино- дунд хугацааны бохирын урсацын түвшин харьцангуй бага тул, тэдгээрийг солих эсхүл урсацын түвшин нэмэгдэхэдзориулан солих, хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагагүй. Санал болгож буй төслийн бүх аймгууд гол биологи цэвэрлэгээний аргаар, тогтвортжуулах /исэлдүүлэх/ цөөрөм бүхий бохир ус цэвэрлэх байгууламжтай /БУЦБ/. Зарим тохиолдолд (Дундговь, Хэнтий) цөөрмийн систем нь урьдчилсан /сараалж, элс баригч/ болон анхан шатны /тунгаагуур/ байдаг. Хэдий тийм боловч эдгээр урьдчилсан цэвэрлэгээний блокууд нь бүрэн хүчин чадлаараа ажилладаггүй. Ихэнх тохиолдолд цэвэрлэх байгууламж нь: (i) засвар үйлчилгээ хангалтгүй, (ii) монголын цаг агаарын нөхцөлд зохицоогүй технологи ашигладаг, (iii) монголын бохир ус зайлцуулах стандартад нийцсэн тогтвортой түвшний цэвэрлэгээ хийдэггүй байна. Үүнээс гадна, Засгийн газраас орон сууцжуулах хөтөлбөр<sup>4</sup> эрчимтэй дэмжиж байгаатай уялдан төслийн эдгээр аймгийн төвүүд хурдацтайхөгжиж байна. Ойрын арван жилд баригдах шинэ орон сууцны хороолол нь бохир усны урсацыг ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлж, одоогийн ЦБ-уудын хүчин чадал хүрэлцэхгүй байдалд хүргэх болно.

3. **Төслийн цар хүрээ.** Нэмэлт санхүүжилт нь одоо сайн хэрэгжиж байгаа төслийн цар хүрээг нэмэгдүүлэх, өргөжүүлэхэд Засгийн газарт туслалцаа үзүүлнэ. Засгийн газрын хүсэлтээр энэхүү төслөөр : (i) нэмэлтээр Баруун-Урт, Булган, Чингис, Мандалговь болон Мөрөн зэрэг аймгийн төвүүдэд шинээр ЦБ барихын тулд төслийн газар зүйн хамрах хүрээг өргөжүүлэх; (ii) төслийн бүх аймагт ялгадас лаг цуглуулах, цэвэрлэх төхөөрөмж нийлүүлэх; (iii) ЗӨГХБХОСГХТ-ийн хүрээнд хийгдсэн байгууллагын шинэчлэл ба чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг Баруун-Урт, Булган, Чингис, Мөрөн болон Мандалговь хотуудад хэрэгжүүлнэ. Ингэснээр, бохир ус зайлцуулах, бохир усиг дахин ашиглах Засгийн газрын стандартыг бий болгох, орон нутгийн байгаль орчны чанар сайжрах зэргээр төслийн гол үр нөлөө өргөжинэ. Төсөл нь улс орны хоёрдугаар зэрэглэлийн хотуудын хөгжилд хувь нэмэр оруулснаар хот-хөдөөгийн харилцааг бэхжүүлэн хотыг илүү тэнцвэртэй болгоход хувь нэмэр оруулах юм. Энэ нь байгаль орчны нөхцөлийг сайжруулахаас гадна төслийн хотуудын байгаль орчны бохирдлыг бууруулна. Төсөл нь төсөлд хамрагдах бүх аймгуудын бохир усны менежмент, гэр хорооллын эрүүл ахуйн

<sup>1</sup> 2016 оны 4-р сард батлагдаж, ADF-аар дамжуулан зээлсэн \$ 19.48 сая долларыг оролцуулсан эхний нэмэлт санхүүжилт багтана. Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл, Нэмэлт санхүүжилтийн төлөвлөсөн зээл, техникийн туслалцааны тэтгэлэг, Манила.

<sup>2</sup> ЗӨГХБХОСГХТ нь Архангай, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай аймагт бохир усны менежментийг сайжруулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

<sup>3</sup> Аймгийн захиргааны өмнөөс хэрэглээний ус, бохир усны менежмент, үйл ажиллагааг хариуцан ажилладаг байгууллагууд.

<sup>4</sup> 100000 айлыг орон сууцжуулах хөтөлбөр

шинэлэг тогтолцоог хэрэгжүүлэх, шинээр ЦБ барих замаар хотуудын бохир усны менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ<sup>5</sup>. Төсөл нь төслийн удирдлага, чадавхийг бэхжүүлэх, сургалт зохион байгуулахад туслалцаа дэмжлэг үзүүлнэ.

## II. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд ба ГЧНШ-ийн нөлөөллийн цар хүрээ

### A. Булган аймаг

4. **Төслийн цар хүрээ.** Булган аймгийн одоогийн цэвэрлэх байгууламж нь аймгийн төвөөс 3 км зайд 4-р багийн нутаг дэвсгэрт байрладаг. Цэвэрлэх байгууламжийн эргэн тойронд суурьшлын бус байхгүй. Төслийн хүрээнд одоо байгаа цэвэрлэх байгууламжийн хажууд шинээр цэвэрлэх байгууламж барих, мөн насос станцын өргөтгөлийн ажлууд хийгдэнэ.

5. **Албадан газар чөлөөлөлтийн нөлөөллийг тодорхойлох, зөвлөлдөх уулзалтууд.** 2017 оны 12-р сар болон 2018 оны 1-р саруудад Булган Мээж ХХК-ны холбогдох ажилтнуудад АХБ-ны Нийгмийн хамгааллын бодлогын баримт бичиг, МУ-ын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн талаарх холбогдох хууль тогтоомжуудын талаар танилцуулах зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан.

6. Хэрэглээний болон бохир усны үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагааг хариуцах, нийтийн аж ахуйн үйлчилгээг иргэдэд үзүүлэх байгууллага нь Булган Мээж ХХК юм.

- Шинэ цэвэрлэх байгууламж:** Одоо байгаа цэвэрлэх байгууламжийн хойд талд зэрэгцээ шинэ цэвэрлэх байгууламж баригдана. Эргэн тойронд ямар нэгэн суурьшил байхгүй. Шинэ, хуучин байгууламжийн аль алиных нь газар нь Булган болон Орхон сумын нутаг дэвсгэрт хуваагдан харьяалагдана. Домын зэвсэг гэж нэрлэгдэх энэ хавийн газрыг ирээдүйд үйлдвэрийн бус болгох төлөвлөгөөтэй. Шинээр байгуулагдах цэвэрлэх байгууламжийн улмаас ямар нэгэн газар чөлөөлөлтийн нөлөөлөл учрахгүй. 2015 онд олгогдсон хуучин захирамжуудыг хүчингүй болгож, 2017 оны 12-р сарын 26-нд Орхон сумын Засаг даргын А/183 тоот захирамж, Булган сумын Засаг даргын А/268 тоот захирамж гарч, Булган-Мээж ХХК-ны нэр дээр Булган аймгийн Булган сумын Газрын албанаас 15 жилийн хугацаатай нийт 24759м2, Орхон сумын Газрын албанаас мөн 15 жилийн хугацаатайгаар 76166м2 газрын гэрчилгээ олгосон байна.
- Хамгаалалтын бус:** Одоогоор албан ёсоор хамгаалалтын бус тогтоож байгаагүй бөгөөд 2018 оны 6-р сард Аймгийн ИТХ-аар хамгаалалтын бүсийг батлуулна. Ямар ч тохиолдолд тухайн байршилд 500м дотор ямар нэгэн суурьшил болон барилга байгууламж байхгүй болно. (Хавсралт 1-ийг үзнэ үү).
- Насос станцын өргөтгөл:** Насос станц нь одоогоор 700м2 газартай. Газар нь Булган Мээжийн эзэмшлийн газар. Шинээр өргөтгөл хийхдээ хажуу дахь нийтийн эзэмшлийн газраас нэмж олгоно. Мөн Булган-Мээжийн харьяаны 2 шонгийн модыг шилжүүлэн байрлуулна. Төр ямар нэгэн нөлөөлөл учрахгүй.
- Цахилгаан, дулаан, усан хангамж:** Цэвэрлэх байгууламжийн цахилгаан хангамжийг ойр байрлах 1000квт-ийн шонгоос татна. Замд нь ямар нэгэн саад учрахгүй. Дулааны асуудлыг хашаан дотроо уухын зуух байгуулан шийднэ. Усан хангамжийг зөөврийн байхаар тооцсон.

7. **ГЧНШ-ийн нөлөөллийн цар хүрээ.** Ямар нэгэн ГЧНШ байхгүй болно.

<sup>5</sup> ТА9100-MON: Гэйтын Сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй Гэр хорооллын ялгадас лагийн менежментийн төслийн арга дээр тулгуурласан.



Шинээр барих ЦБ-ын талбай



Насос станцын өргөтгөл



Бүрэлдэхүүн хэсэгт багтах 2 шон

## B. Дундговь аймаг

8. **Дэд төслийн цар хүрээ.** Сайнцагаан буюу Мандалговь хотод шинээр хийгдэх цэвэрлэх байгууламжийн зураг төсөл нь бусад аймгуудын адил хоногт 3000м3 бохир цэвэрлэх хүчин чадалтай юм.

9. Хэрэглээний болон бохир усны үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагааг хариуцах, нийтийн аж ахуйн үйлчилгээг иргэдэд үзүүлэх байгууллага нь Дундговь-Ус ОНӨҮГ юм.

10. **Албадан газар чөлөөлөлтийн нөлөөллийг тодорхойлох, зөвлөлдөх уулзалтууд.** Энэхүү ажлын үеэр газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ямар нэгэн нөлөөлөл гарах эсэхийг тодруулахаар төслийн багийн гишүүд, Дундговь-Ус ОНӨҮГ-ын дарга, инженер, орон нутгийн холбогдох албаны хүмүүстэй хамт газар дээр 2017 оны 12-р сарын 27, 28 болон 2018 оны 1-р сарын 21-нд нийт 2 удаа нь ажиллав. Үүнээс гадна Дундговь-Ус ОНӨҮГ-ын холбогдох ажилтнуудад АХБ-ны Нийгмийн хамгааллын бодлогын баримт бичиг, МУ-ын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн талаарх холбогдох хууль тогтоомжуудын талаар танилцуулах зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан.

11. 2018 оны 01-р сарын 02-нд Аймгийн Засаг даргын А/02 тоот захирамжаар цэвэрлэх байгууламжийн зориулалтаар Мандалговь хотын 3-р багийн нутаг дэвсгэр дээр, одоо байгаа цэвэрлэх байгууламжаас урагшаа 2,1 км орчимд ЗДТГ-т 23,1 га газрыг 30 жилийн хугацаатай олгосон. Мөн энэхүү захирамжаар хамгаалах бүсийг 150м-ээр тогтоосон. (Хавсралт 2-ыг үзнэ үү).

- a. **Шинээр цэвэрлэх байгууламж барих:** Энэ газарт ямар нэгэн суурьшилт, өмч хөрөнгө байхгүй, эзгүй хоосон газар байна. Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ямар нэгэн нөлөөлөл учрахгүй бөгөөд өмнө нь хэн нэгэнд газар олгох буюу ашиглуулж байгаагүй болно. Шинээр сонгосон байршил нь одоогийн ЦБ-тай ойрхон, өмнө нь газар төлөвлөлт хийгдэж байгаагүй хотын зүүн хэсэгт байрладаг, ямар нэгэн газар чөлөөлөлтийн асуудал байхгүй. Нийт олгогдсон талбайн хэмжээ 2,3 га байна.
- b. **Цэвэрлэх байгууламжийн дулаан, цэвэр усны хангамж:** Төлөвлөгдөж байгаа байгууламжийн дулааныг өөрийн газар дээр уурын зуух барих замаар шийднэ. Усан хангамжийн асуудлыг одоогийн цэвэрлэх байгууламжийн урдуур гарсан цэвэр усны шугамнаас ойролцоогоор Зкм орчим газраас татна.
- c. **Бохирын 2,1 км шугамыг шинэхэн барьсан өргөх насоснаас татна.** Энэхүү шугамыг өмнө нь хэн нэгэнд олгож байгаагүй нийтийн эзэмшлийн болон Дундговь-Ус компаниййн эзэмшлийн газар дээр хийх тул ямар нэгэн нөлөөлөл учрахгүй.
- d. **Цахилгааны хангамж:** Цахилгаан хангамжийг одоогийн цэвэрлэх байгууламжийн ЦТП-ээс татахаар төлөвлөж байна. Энд ямар нэгэн ГЧНШ нөлөөлөл учрахгүй.

**12. ГЧНШ-ийн нөлөөллийн цар хүрээ.** Ямар нэгэн ГЧНШ байхгүй болно.



Одоогийн ЦБ ба өргөлтийн насос станц



Шинээр ЦБ байгуулахаар төлөвлөсөн талбай

## C. Хэнтий аймаг

13. **Дэд төслийн хүрээ.** Дэд төслийн хүрээнд шинээр ЦБ барих, одоогийн насос станцыг өргөтгөх болон бусад ажлууд хийгдэнэ.
14. Хэрэглээний болон бохир усны үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагааг хариуцах, нийтийн аж ахуйн үйлчилгээг иргэдэд үзүүлэх байгууллага нь Хэнтий-Ус ХХК юм.
15. **Албадан газар чөлөөлөлтийн нөлөөллийг тодорхойлох, зөвлөлдөх уулзалтууд.** Төслийн ажлын үеэр газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ямар нэгэн нөлөөлөл гарах эсэхийг тодруулахаар төслийн багийн гишүүд, Хэнтий-Ус ХХК-ний дарга, инженер, орон нутгийн холбогдох албаны хүмүүстэй хамт газар дээр 2017 оны 12-р сар болон 2018 оны 1-р сард нийт 2 удаа нь ажиллав.
  - a. **Шинэ ЦБ:** Шинэ ЦБ-ыг одоогийн цэвэрлэх байгууламжийн баруун хойд талд байгуулахаар зураг төсөл нь хийгдсэн. Цэвэрлэх байгууламжид 2018 оны 03-р сарын 01-нд аймгийн Засаг даргын А/83 тоот захирамжаар нийт 150671м<sup>2</sup> газрыг 47 жилийн хугацаатайгаар олгосон. (Хавсралт 4).
  - b. **Хамгаалах бүс:** 2018 оны 02-р сарын 07-ны ИТХ-ын 7-р хуралдааны 2-р хурлаар хамгаалах бүсийг 100м-ээр тогтоосон.
  - c. **Насос станц:** Нийт талбай нь 200м<sup>2</sup>. Хэрлэн сумын 4-р багийн нутаг дэвсгэрт оршдог энэхүү газар нь Хэнтий-Ус ХХК-ний эзэмшлийн газар юм.
  - d. **Цахилгаан болон дулаан хангамж:** Шинэ ЦБ-ын цахилгаан болон дулаан хангамжийг одоогийн байгаа сүлжээнээс авахаар төлөвлөсөн.
  - e. **Усан хангамж:** ЦБ-ын усан хангамжийг дотроо гүний худгаар шийдэгдэнэ.
16. **ГЧНШ-ийн нөлөөллийн хүрээ.** Дэд төслийн нөлөөлөлд өртөх 2 НӨИ байна.
  - a. **Шинэ ЦБ.** Одоогийн цэвэрлэх байгууламжийн зүүн талд орших СЕКТЭК ХХК-ний эзэмшлийн газраас хэсэг газар нь ЦБ-д шинээр олгох газартай давхцаж байгаа. Тус компани нь төлөвлөгдөж буй ЦБ-ын зүүн талд нийтдээ 16,003 м<sup>2</sup> газар эзэмшдэг бөгөөд газар дээр ямар нэгэн барилга, байгууламж байхгүй.
  - b. **Хамгаалах бүс.** “Жипел” ХХ компанийн нэр дээрх эзэмшлийн газар дээр байгаа бутлуурын үйлдвэр нөлөөлөлд өртөнө. Бутлуурын үйлдвэр нь улирлын чанартай ажлаа явуулдаг. Өөрийн хөрөнгөөр 40м-т гүний худаг гаргуулсан. Компанийн манаач эмэгтэйн гэр бүл компанийн газар дээр, гэрт амьдардаг.
17. **Зөвлөлдөх уулзалт.** 2018 оны 1-р сарын 15, 2-р сарын 13-нд нөлөөлөлд өртсөн иргэдтэй уулзалт хийсэн. Аль аль компани нь төслийн үйл ажиллагааг дэмжиж буйгаа илэрхийлж, шинээр олгох байршил руу газраа шилжүүлэхээ мэдэгдсэн.
  - СЕКТЭК ХХК-ний хувьд, компани нь давхардсан газрын оронд нөгөө тал руу газраа шилжүүлэхээр зөвшилцсөн.
  - “Жипел” ХХК-д өөр байршилд шинээр газар олгох бөгөөд компани нь уг байршлыг зөвшөөрсөн. 40м гүний худаг гаргасан зардал болох 6 сая төгрөгийг нөхөн олговор болгож авах хүсэлтээ гаргасан. Хамтарсан хурлын протоколд худгийн зардалтай холбоотой бүхий л бичиг баримт байгаа талаар дурьджээ. Компани нь Засгийн газарт манаач эмэгтэй болон түүний гэр бүлийг нүүлгэх, цаашдын амьдралын түвшинг дордуулахгүй байх арга хэмжээ авахаа баталгаажуулсан. Эдгээр өрх нь ядуу, эмзэг бүлэгт харьяалагдах ба нэг гишүүн нь хараагүй хүүхэд байна. Манаач эмэгтэй нь 1 жил гаруйн хугацаанд цалин хөлсөө аваагүй, өөрийн 7 ш гахайн үр төлийг зарж амьдардаг, тэтгэвэр авдаг. Охин нь тусдаа гэрт 3 хүүхдийн хамт амьдардаг, түүний нэг охин нь

хараагүй. Энэ 2 айл нь ядуу, хөгжлийн бэрхшээлтэй 2 хүнтэй байна. Төслийн ажлыг дэмжиж байгаа ба шинээр нүүж очих газар нь цахилгаантай байвал өөр хүсэх зүйл алга гэж байна. Энэ талаар аймгийн Засаг даргад уламжилсан ба цаашид ажил олгогч нь үүргээ биелүүлсэн эсэхэд төсөл хяналт тавих шаардлагатай.

18. Хавсралт 3-т шинээр газар олгох, нөхөн олговор авах, хурлын тэмдэглэл, 2 компаниас ирүүлсэн албан тоот зэрэг газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой баримт бичгүүдийг харууллаа.



Одоогийн байршил



Төлөвлөж буй байршил



Насос станцын өргөтгөл нь одоогийн хашаан дотор хийгднэ.



Чулуу бутлуурын тоног төхөөрөмж



Чулуу бутлуурын үйлдвэр



Аймгийн захиргаа нь дээрх 2 өрхөд туслалцаа үзүүлэх, мөн таслийн нэгжээс хяналт тавих шаардлагатай.



#### D. Хөвсгөл аймаг

19. **Дэд төслийн цар хүрээ.** БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2015.05.25-нд гаргасан ЗД/2015-07/20 тоот Хөвсгөл аймгийн Мөрөн сумын цэвэрлэх байгууламжийн өргөтгэл шинэчлэлийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын дагуу Мөрөн суманд 1/ шинээр цэвэрлэх байгууламж барих, 2/ бохир усны дамжуулах станцыг өргөтгөх, 3/ цэвэрлэх байгууламжийн дулаан, цэвэр усны хангамжийн зураг төсөл, 4/ цахилгааны хангамжийн зургийг 2 талын эх үүсвэртэй байхаар зураг төсөл хийгдсэн.

20. **Үйл ажиллагаа, зохион байгуулалт.** Хэрэглээний болон бохир усны үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагааг хариуцах, нийтийн аж ахуйн үйлчилгээг иргэдэд үзүүлэх байгууллага нь Хөвсгөл-Ус ХХК юм. Хөвсгөл Ус ХХК нь өмнө нь ОСЧААК нэртэй байсан. Үүнээс гадна өөр 2 НААҮГ байсан (Хөвсгөл дулаан ХХК, Хөвсгөл-Ус Чандмань ХХК) бөгөөд бүгд тусдаа газрын гэрчилгээтэй байжээ. Одоо бүгд нэгдэж Хөвсгөл Ус ХХК-ний нэрийн дор үйл ажиллагаагаа явуулах болсон. Хавсралт 4-т Хөвсгөл Ус ХХК-ний газрын захирамжийг харуулав.

21. **Албадан газар чөлөөлөлтийн нөлөөллийг тодорхойлох, зөвлөлдөх уулзалтууд.** Төслийн ажлын үеэр газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ямар нэгэн нөлөөлөл гарах эсэхийг тодруулахаар төслийн багийн гишүүд, Хөвсгөл-Ус ХХК-ний дарга, инженер, орон нутгийн холбогдох албаны хүмүүстэй хамт газар дээр 2017 оны 12-р сарын 21, 2018 оны 1-р сарын 24-25-нд уулзалтууд хийллээ. Энэ үеэр АХБ-ны Нийгмийн хамгааллын бодлогын баримт бичиг, МУ-ын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн талаарх холбогдох хууль тогтоомжуудын талаар танилцуулах зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан.

22. **ГЧНШ-ийн нөлөөллийн хүрээ.** Дэд төслийн хүрээнд ямар нэгэн ГЧНШ байхгүй болно. Холбогдох баримтуудыг Хавсралт 5-аас үзнэ үү.

- Шинээр цэвэрлэх байгууламж барих.** Шинээр олгогдсон газрын хязгаарт багтаж барилгын ажил хийгдэнэ. Энэ нь одоогийн ЦБ-ын хажууд бөгөөд энд ямар нэгэн газар чөлөөлөлт гарахгүй. Энэ газрыг өмнө нь хэн нэгэнд олгож байгаагүй болно.

- b. Хамгаалах бүс.** 2017 оны 12-р сарын 25-нд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 158 тоот тогтоолоор цэвэрлэх байгууламжийн хамгаалалтын бүсийг 300м, хязгаарлалтын бүсийг 150м-ээр тогтоосон. Хязгаарлалтын бүс дотор улсын төсвийн хөрөнгөөр дутуу баригдсан 2 давхар барилганаас өөр газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ямар нэгэн нөлөөлөл учрахгүй. Энэхүү барилгыг ашиглах нь аюултай ба энэ асуудлыг тусад нь шийдвэрлэнэ.
- c. Бохир дамжуулах станцыг өргөтгөх.** Бохирын төв дамжуулах станцын өргөтгөл нь одоогийн байрлах төмөр хашааны хүрээнд буюу байшин дотроо хийгдэх тул нэмэлт ямар нэгэн нөлөөлөл гарахгүй. Барилгын ажлын үеэр түр нөлөөлөл мөн учрахгүй.
- d. Цэвэрлэх байгууламжийн дулаан, цэвэр усны хангамж.** Хэрэглээний ус болон дулааныг одоо байгаа дулааны станц болон усан хангамжийн системээс хангана. Дулааны станцаас дулааны 2 шугам, хэрэглээний халуун усны 2, хүйтэн усны 1 гээд нийт 5 шугам хоолойгоор дамжуулан авна. Шугам хоолой нь одоо баригдсан байгаа нийт 4 блокон болон модон хашааны урдуур хангалттай зайнд гарах тул ямар нэгэн нүүлгэн шилжүүлэлт гарахгүй.
- e. Цахилгааны хангамж.** Энэ нь 2 талын эх үүсвэртэй байхаар хийгдэж байгаа ба “А” тэжээл нь (хойноос гэр хорооллын дундуур ирнэ) хуучин насос станцаас шинэ цэвэрлэх байгууламжийн гадна хүртэл 1140м, “Б” тэжээл нь гэр хорооллын одоо байгаа цахилгааны шугамыг шинэчилж, 13-р шонгоос цэвэрлэх байгууламж хүртэл 1080м үргэлжлэх юм. Энд ямар нэгэн ГЧНШ нөлөөлөл учрахгүй.



Одоогийн ЦБ-ын талбай



Шинэ барих ЦБ-ын талбай



Хамгаалах бүсэд байрлах дутуу баригдсан барилга



Өргөлтийн насос станц



## E. Сүхбаатар аймаг

**23. Төслийн цар хүрээ.** 1971 онд байгуулагдсан одоогийн цэвэрлэх байгууламж нь аймгийн төвөөс зүүн урагш 2,5 км-т байрладаг. Шинээр баригдах цэвэрлэх байгууламжийг одоогийн байгаагаас урагш 1 км зайд байгуулахаар төлөвлөсөн. Тус аймаг нь 2032 оныг хүртэлх аймгийн Мастер төлөвлөгөөтэй. Ирээдүйд суурьшлын бүсээс хол байлгах зорилгоор шинэ цэвэрлэх байгууламжийг аймгийн төвөөс алслагдсан зайд барихаар төлөвлөсөн байна.

- a. **Шинэ цэвэрлэх байгууламж.** Шинээр баригдах байгууламж нь аймгийн төвөөс 3,5 км зайд оршино. Энэ хавьд ямар нэгэн суурьшил байхгүй, газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл учрахгүй. Энэ газрыг өмнө нь хэн нэгэнд олгож байгаагүй болно. Нийт газрын хэмжээ 6,8 га ба хамгаалах бүсийг 500м-ээр тогтоосон. Энд ГЧНШ-ийн ямар нэгэн нөлөөлөл учрахгүй. Хавсралт 6-г үзнэ үү.
- b. **Цахилгаан, дулаан, усан хангамж.** Цэвэрлэх байгууламжийн цахилгаан хангамжийг 2 эх үүсвэртэй байхаар шийдсэн. Дулааны асуудлыг хашаан дотроо уухын зуух байгуулан шийднэ. Усан хангамжийг зөөврийн байхаар тооцсон. Эдгээр ажлуудыг хийхэд ямар нэгэн газар чөлөөлөлт гарахгүй.



Одоогийн ЦБ



Төлөвлөж буй байршил нь аймгийн төвөөс 3.5 км зайдтай.



### III. Хууль, Бодлогын хамрах хүрээ, Авах туслалцаа

23. Зорилго, хууль болон бодлогын хамрах хүрээ нь АХБ-ны Нийгмийн хамгааллын Бодлогын баримт бичгийн дагуу хийгдсэн бөгөөд нөлөөлөлд өртсөн иргэд зохих туслалцаа, нөхөн олговор авсан эсэх, иргэдийн амьжиргааг наад зах нь төслийн өмнөх үеэс дордуулахгүй хэвээр хадгалахын тулд төслийн төлөвлөлтөнд оролцуулах боломжоор хангахад чиглэсэн туслалцааг үзүүлнэ гэсэн үг юм. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нөлөөлөлд өртөгчдийг төслийн талаарх мэдээллээр хангах, ойр дотно зөвлөлдөх, учирсан хохирлыг нь нөхөн олгох, орлуулах газар, өмч хөрөнгийг эзэмших, өмчлөхөд туслалцаа үзүүлнэ.

24. Энэхүү ГЧНШТ-ний бүх заалт нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, АХБ-ны 2009 оны Нийгмийн хамгааллын бодлогын баримт бичиг (НХБББ)-ийн дагуу байна. Үндэсний хууль тогтоомжид МУ-ын Үндсэн хууль, Газрын тухай хууль, МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Иргэний хууль багтана.

25. АХБ-ны НХБББ-ын дагуу “Туслалцаа авах эрхийг тасалбар болгох өдөр”-өөс өмнө оршин сууж байсан бүх нөлөөлөлд өртсөн өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, хууль ёсны оршин суугч, зөвшөөрөлгүй иргэн болон түрээслэгчид туслалцаа авах эрхтэй. Нөлөөлөлд өртсөн газар, өмч хөрөнгөнд нөхөн олговор олгоходо орлуулах үнийн зарчмаар тооцно.

26. Төслийн хувьд, ГЧНШ-ийн нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах бүхий л арга хэмжээг авсан. Тухайлбал, ЦБ-д зориулсан газар нь хоосон, ашиглагдаагүй газар дээр байсан тохиолдолд хамгаалах бүсийг бууруулсан. Гэхдээ нөлөөллөөс зайлсхийх боломжгүй нэг байршил байна. Энд тухайн компани шинэ байршилд нүүж очоод ажлаа хэвийн явуулах хугацаа хангалттай учир ямар нэгэн бизнесийн алдагдал гарагчгүй. 2-р хэсэгт дурьдсанчлан, тухайн байршилд 2 компани нөлөөлөлд өртөнө. Нөлөөллийн байдлаас шалтгаалан доорх хүснэгтэнд хэн, ямар туслалцаа, нөхөн олговор авахыг харуулав.

27. Төслийг албан ёсоор зарласан, төслийн байршил тодорхой болсон, нөлөөлөлд өртөгчдийн тооллого судалгааг хийсний дараа газрын наймаа, зөвшөөрөлгүй иргэдийн хэт ургалаас урьдчилан сэргийлэхийн тулд “Туслалцаа авах эрхийг тасалбар болгох өдөр”-ийг тогтооно. Энэ төслийн тухайд төслийн байршууд тодорхой болсон ба компаниудад хурал хийх, захидал илгээх байдлаар албан ёсны мэдэгдэл хүргүүлсэн болно.

## Хүснэгт 1: Туслалцаа авах эрх ба авах туслалцаа

Хохирлын төрөл	Туслалцаа авах эрхтэй иргэд	Авах нөхөн олговор, туслалцаа
Газар ( Эзэмшсэн газар)	2 хувийн компани: СЭКТЕК Групп ХХК Жипел ХХК	Энэ 2 компанид газрыг газраар нөхөн олгоно.  Жипел ХХК-ний хувьд, эмэгтэй манаачийн гэр бүл болон хажууд нь хамт амьдардаг түүний охины гэр булийг Засгийн газраас олгох шинэ байршилд нүүлгэх ажлыг хариуцна. Эдгээр гэр бүлүүдэд шаардлагатай аливаа зардал, тусламжийг тухайн компани хариуцна <sup>6</sup> .
Нөлөөлөлд өртсөн гүний худаг	Жипел ХХК	Орлуулах үнийн зарчмаар бэлэн мөнгөний нөхөн олговор олгоно. Элэгдэл хорогдол тооцохгүй.
Урьдчилж харах боломжгүй нөлөөлөл	Тодорхойгүй	Төслийн хэрэгжилтийн явцад учрах, урьдчилан харах боломжгүй байсан нөлөөлөл; Энэ тохиолдолд АХБ-ны бодлогын дагуу тохирох арга хэмжээг авч, хэрэгжүүлэхээс өмнө АХБ-д тайлagnana.
Нөлөөлөлд өртсөн байгууламж	Барилга, байгууламж өмчлөгч (тодорхойгүй)	Төслийн хэрэгжилтийн явцад ямар нэгэн барилга байгууламж нөлөөлөлд өртөхөөр бол нөхөн олговрыг орлуулах үнийн зарчмаар тухайн үеийн зах зээлийн ханшаар, элэгдэл хорогдол тооцохгүй олгоно. Мөн ажлын хөлс, тээврийн зардлыг олгоно. Мөн аварч болох материалын үнийг нөхөн олговоос суутгахгүй.

## IV. Гомдол барагдуулах механизмын төслийн төрөл

28. НААҮБ тус бүр төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой (байнгын болон түр нөлөөлөл, газар ашиглах эрхийг хязгаарласан) нөлөөлөлд өртсөн иргэн/байгууллагаас гаргасан аливаа гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, баримтжуулах ажилтаныг томилно.

29. Гомдлын маягт (ГМ)-ыг газар чөлөөлөх ажиллагааны олон янзын талыг хамрахад зориулсан бөгөөд гомдол барагдуулах явцад ашиглана. ГМ-ыг гомдлыг ил тод байдлаар мэдүүлэх, эргэн шалгахад ашиглана (ГМ-ын жишээг Хавсралт 7-д харуулав). Мэдүүлсэн бүх гомдлыг ГМ-д тэмдэглэх бөгөөд хувийг гомдол мэдүүлж байгаа этгээдэд хүргүүлнэ. ГМ-д дараахийг дурдана:

- Нэр, холбоо барих мэдээллийг оролцуулаад гомдол мэдүүлж байгаа нөлөөлөлд өртсөн аж ахуйн нэгжийн тухай талаарх үндсэн мэдээлэл;
- Сүүлийн уулзалт хийгдсэн өдөр
- Мэдүүлсэн гомдлын ангилал (хууль зүй, техник/инженеринг, нийгэм эсвэл санхүүгийн);
- Гомдлын дэлгэрэнгүй тодорхойлолт;
- Авсан арга хэмжээний төрөл (АХ-ийн түвшинд шийдвэрлэсэн эсвэл эрх бүхий байгууллагад шилжүүлсэн)

30. НААҮБ тус бүр гомдлыг бүртгэх системийг бий болгож, бүх гомдол саналын тэмдэглэл болон хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг хадгална. НААҮБ нь Газрын алба болон

<sup>6</sup> Эдгээр өрхөд туслалцаа үзүүлэх, амьжираагаага нь дордуулахгүй байхад анхаарна гэдгээ Жипел ХХК мэдэгдсэн ба энэ талаар хурлын тэмдэглэлд дурьдсан байгаа.

холбогдох төрийн байгууллагуудын ажилтнуудын тусламжтайгаар аливаа гомдол саналыг аль болох эрт үед нь шийдвэрлэхийг эрмэлзэнэ. ГБМ-ын үйл ажиллагаа нь дараахь байдлаар явагдана:

- Алхам 1: Хохирсон НӨИ гомдлоо НААУБ-ын гомдол барагдуулах ажилтанд гаргаж, ажилтан нь ГБМ-ын дагуу бүртгэж авна. Дараа нь ТҮН, газрын алба болон бусад холбогдох байгууллагын хариуцсан ажилтантай холбоо барина. 1 долоо хоногийн дотор гомдлыг танилцуулах, хэлэлцэх, шийдвэрлэх ажиллагаа хийгдэнэ. НААУГ-ын гомдол барагдуулах ажилтан гомдлын талаарх өөрийн зөвлөмжийг тэмдэглэж, тухайн 7 хоногтоо багтааж олж авсан мэдээлэл, зөвлөмжүүдийг холбогдох байгууллагуудад мэдэгдэх ба ТҮН, ГХБХБГ-т танилцуулна.
- Алхам 2: Гомдлыг бүртгүүлснээс хойш 2 долоо хоногийн дотор шийдвэрлэж чадаагүй бол холбогдох сумын холбогдох газар/байгууллагад шийдвэрлүүлэхээр хүргүүлнэ. Гарсан шийдвэрийг аймгийн Засаг даргаар батлуулах ба Аймгийн Засаг дарга нь ахин нэг 7 хоногийн дотор багтааж асуудлыг шийдвэрлүүлэх үйл ажиллагаа явуулна.
- Алхам 3: Хэрэв өмнөх оролцогч талууд гомдлыг шийдвэрлэж чадаагүй бол, асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

31. Газрын тухай хуульд заасны дагуу газрын маргааныг тодорхойлсноор (60 дугаар зүйл, "Газартай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэх"), маргааныг тухайн хорооны Засаг дарга шийдвэрлэнэ. Энэхүү шийвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд, маргааныг дээд шатны байгууллагаас эсхүл шүүхээр шийдвэрлэх болно. Өөр нэг арга нь оршин суугчид нь тус дүүргийн Газрын мэргэжилтэнд шууд хандах боломжтой.

32. Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртсөж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага асуудлаа шийдвэрлүүлэхээр АХБ-ны төслийн багтай хамтран ажиллаж хангалттай хүчин чармайлт гаргасан боловч өргөдөл, гомдлыг нь шийдвэрлэх явцад сэтгэл хангалиун бус байж, дэд төсөл нь АХБ-ны бодлого, зарчмыг зөрчсөний улмаас түүнийг нь хохироосон гэж үзэж байвал, тэрээр өргөдөл гомдлоо АХБ-ны хариуцлага хүлээх механизмын дагуу тус банкны Төслийн тусгай албанад эсвэл Өргөдөл гомдол хянах албанад гаргаж болно. Энэ өргөдөл гомдлыг хэрхэн гаргах талаарх мэдээллийг АХБ-ны интернет дэх [www.adb.org/site/accountability-mechanism/main](http://www.adb.org/site/accountability-mechanism/main) хаягаар орж авах боломжтой.

## V. Хэрэгжүүлэх арга зам

33. БХБЯ нь нэмэлт санхүүжилтийн төслийн гүйцэтгэх ба хэрэгжүүлэгч агентлаг нь бөгөөд одоо байгаа ТҮН-ээр дамжуулан чиг үүргээ хэрэгжүүлнэ. ТҮН нь энэхүү төслийн улмаас үүрэг хариуцлагаа өргөжүүлнэ.

34. Аймгийн түвшинд, төслийн хяналтыг НААУБ-аас томилогдсон хагас цагаар ажиллах ажилтанаас бүрдэх дэмжих нэгжээр дамжуулан хэрэгжүүлнэ. ТҮН-д зээлийн төслийн хүрээнд хөлсөөр ажиллах зөвлөхүүдийн тусламжтайгаар төслийн удирдлага, хэрэгжилтэнд туслалцаа үзүүлнэ. Төслийн удирдлага, хэрэгжилтийг дэмжих зөвлөх нь төслийн удирдлага, худалдан авалт, хяналт, нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилт болон мониторингийн чиглэлээр ТҮН, НААУБ-ийн дэмжих нэгжид туслалцаа үзүүлнэ.

## VI. Хэрэгжилтийн хуваарь ба Мониторинг

35. Төсөл хэрэгжүүлэх хугацаа 2018 оны 7-р сараас 2021 оны 12-р сар хүртэл байна. Хэрэгжилтийн явцад зураг төсөлд ямар нэгэн өөрчлөлт гарч ГЧНШ-ийн нөлөөлөлд өөрчлөлт орох эсхүл шинээр нөлөөлөл учирвал, энэхүү ГЧНШТ-ийг шинэчилж, газар чөлөөлөлт хийхээс өмнө АХБ-д батлуулахаар хүргүүлнэ.

36. Барилгын ажил эхлэхээс өмнө ТҮН нь ГЧНШ-ийн хэрэгжилтийн талаар тайлагнана. Ялангуяа, цаг тухайд нь нөлөөлөлд өртсөн 2 компанийд газар олгох, гүний худагт нөхөн олговор олгосон байна.

37. Нөхөн олговор олгох, нүүх ажиллагаа бүрэн дуусаагүй тохиолдолд барилгын ажлыг эхлүүлэхгүй.


38. ТҮН нь ГЧНШ-ийн хэрэгжилтийг хянана. Төслийн хагас жилийн тайланд ГЧНШ-ийн хэрэгжилтийн тухай нэг хэсэг оруулна. Үүнд хийгдсэн зөвлөлдөх уулзалтууд, иргэдээс гаргасан гомдол, тэдгээрийг хэрхэн шийдсэн тухай, шинээр газар олгосон эсэх, нөхөн олговрыг олгосон эсэх, Жипел компанийн эмэгтэй манаачийн тэр бүлд үзүүлсэн туслалцаа зэрэг мэдээллийг багтаасан байна.

## **VII. ГЧНШТ-НИЙ ӨРТГИЙН ҮНЭЛГЭЭ**

39. ГЧНШТ-ний өртөг нь нөлөөлөлд өртсөн гүний худгийн нөхөн олговрын үнэ буюу 6 сая төгрөг байна. Төслийн хэрэгжилтийн явцад худгийн үнэ нь төлбөр хийх үеийн орлуулах үнэ мөн эсэхийг баталгаажуулна. Захиргааны зардлыг МУ-ын Засгийн газраас оруулах хөрөнгөнөөс мөн зөвлөх үйлчилгээнээс гаргана.

# Хавсралтууд

## Хавсралт 1: Булган аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн албан тоот



## Булган ба Орхон сумын Засаг дарга нарын захирамжууд



БУЛГАН АЙМАГ ОРХОН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 4/183

Манилал

Газрын хэмжээг өөрчлөх

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."д", Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэхь заалт, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хавсралтын 21.1.57-д тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбилооны нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын мэдээллийн сангийн өгөгдөлийг засварлах, Геодезийн солбилицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтанд дурьдагдсан Булган Мээж ТӨХК-д газрыг эзэмшүүлсүгэй.
2. Газрын харилцааны хууль, тогтоомжийн дагуу газраа зориулалтын дагуу зүй зохистой ашиглах хамгаалах, нөхөн сэргээхийг газар эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад үүрэг болгосугай.
3. Газар эзэмшигчтэй гэрээ байгуулан гэрчилгээжүүлж, улсын бүртгэлд бүртгэж ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Д.Нямаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.БАТ-ЭРДЭНЭ

2801183



БҮЛГАН АЙМАГ  
БҮЛГАН СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар A/268

Булган

Газрын хэмжээ өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын 4 дүгээр баг Домын дэвсэг 24 дүгээр гудамжны 2401 тоотод байршилтай цэвэрлэх байгууламжийн зориулалтаар Булган аймгийн Дулаан ус хангамж НАА-н Булган Мээж ХХК-д кадастрын зураглалын дагуу 24759 м<sup>2</sup> болгон өөрчилж 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн A/35 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэн олгож, улсын бүртгэлд бүртгэн ашиглалтын байдалд хяналт тавин ажиллахыг газрын даамал /Б.Цолмон-д. Газрын тухай хуулийн дагуу зөв зохицой эзэмшиж ашиглахыг Булган аймгийн Дулаан ус хангамж НАА-н Булган Мээж ХХК-ний захиралд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.НАРАНБАЯР

## Хавсралт 2: Дундговь аймгийн ГХБХБГ-ын албан тоот



2018. 01. 21 № 1/30

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Т АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨСЛИЙН НЭГЖИД

Тус аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаар захирамжаар Сайнцагаан сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт /одоо байгаа цэвэрлэх байгууламжийн урд талд/ байршилтай 231000 м.кв /23,1 га/ газрыг аймгийн ЗДТГ-т цэвэрлэх байгууламжийн зориулалтаар болон хамгаалалтын зурвасыг тал бүр тийшээ 150 м-ээр тогтоон 30 жилийн хугацаатай эзэмшүүлсэн. Уг цэвэрлэх байгууламжийн эзэмшлийн газар нь бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтын газартай давхцаагүй, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт байхгүй болохыг үүгээр баталгаажуулж байна.



D/Alban bichig/toot A5/2018.01-21  
12.01.18

# Дундговь аймгийн Засаг даргын газар олгосон захирамж



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2013 оны 07 сарын 02 одор

Дугаар 1108

Мандзговь


## Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Сайнцагаан сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт /Цэвэрлэх байгууламжийн урд талд/ байршилтай 231000.0 м.кв /23.1 га/ газрыг аймгийн Засаг даргын тамгын газарт /РД:9033548/ "Цэвэрлэх байгууламж барих" зориулалтаар, хамгаалалтын зуравсыг тал бүр тийшээ 150 метрээр тогтоон 30 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

X	Y
1. 599946.680	5065354.439
2. 600276.680	5064782.862
3. 599973.571	5064607.862
4. 599643.571	5065179.439

- Дээрх байгууллагад газар эзэмших гэрчилгээ олгож, гэрээ байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар Л.Төрбат/-д нарт үүрэг болгосугай.



### Хавсралт 3: Хэнтий аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн тоот



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКИНД

**ХЭНТИЙ АЙМАГ  
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

23119, Чингиш хот, Харилан сум,  
Утас/факс: 70-56-30-10

2018.02.22 № 02/22  
таний -ны № -1

Газар нийвэлэх арга хэмжээ авсан  
түхэй

Цэвэрэгэх байгууламжийн оргяныг барихтай холбогдуулан аймгийн ИТХ-ын  
2018 оны 02 дугаар сарын 07-ны одрийн Долоодугаар хуралдааны 02 дугаар  
тогтоолосоо хамгаалалтын бүсийг тэтвөссөн.

Цэвэрэгэх хамгаалагч... бүсийд 'Сектех групп' ХХК, "Жигийн" ХХК-ий өзүүлийг  
байсан газрууд хамрагдаж байсан багаад газрын асуудлыг дараах байдлаар  
шийдвэрлэж ажиллалаа.

Үүнд:  
"Сектех групп" ХХК ийн зүтгэсээ өзүүлийг байгав газрын байршилын зөрчлөхөөн  
татгалзах энэгүйгээ 2018 оны 02 дугаар сарын 05-ны одийн А/8/27 төст  
агва-бичгээс.

ЭКипол' ХХК-ий хувьд эзэмшиж байгаа газраа "Олбор баян төв" ХХС-ий эзүүн  
тапд шилжүүлж авах хүснэлтээ албан бичгээр тус тус ирүүлсэн.

Иймд цэвэрэгэх байгууламжийн өргөнчлийн барилга байгууламж баригдан  
наашаанд чиг ажиншгээг януулжад тахар чөлөөнөхөтэй холбогдсон ямар нэгэн асуудал  
байдхий болсныг үүзээр мэдэгдэж байна.

ДАРГА  
Д.БАЯРХҮҮ

## Хавсралт 4: Хэнтийн аймгийн Засаг даргын газар олгосон захирамж



### МОНГОЛ УЛС ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 01 адар

Дугаар A/83.

Хэрлэн сум

#### Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Захиргааны өрөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 30 дугаар зүйлийн 30.1, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Хэрлэн сумын 5 дугаар баг, Мал эмнэлгийн зүүн талд байрлах 150671 м<sup>2</sup> газрыг, цэвэрлэх байгууламжийн зориулалтаар "Хэнтий-Ус" ХХК-д 47 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
- "Хэнтий-Ус" ХХК-ий эзэмшиж буй газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.
- Газар эзэмших эрхийн төслийг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүргэ болгосугай.
- Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг "Хэнтий-Ус" ХХК /Г.Батгэрэл/-д үүргэ болгосугай.
- Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 93 дугаар захирамжийн хавсралтын 11 дэх хэсэг, Хэрлэн сумын Засаг даргын 2015 оны A/170 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

• 01.20..

## СЕКТЕХ ГРУПП ХХК-ААС ИРҮҮЛСЭН ТООТ



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Н.ГАНБЯМБА ТАНАА

Тус аймгийн Хэрлэн сумын 5-р баг, Цэвэрлэх байгууламжийн эүүн талд 16003 м<sup>2</sup> газрыг Чингис хотын иргэд, аж ахуйн нэлжээс үүсч байгаа хог хаягдлыг ангилж яланг дахин боловсруулах үйлдвэр байгуулах зориулалтаар ашиглахаар газар зэмшүүлэх гарээ байгуулж өргөнгүй олгогдсон.

Манай төсөл 2018 оны 4-р сарын 1-нээс эхлэхээр ТЭЗҮ батлагдаж, эскиз болон ажлын зураг төсөв хийтэй дуусч байна.

Танай аймагт Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэхэд манай зээмшилийн газар бага зэрэг давхцаж байгаа тул аймгийн Газрын алба, Чингис хотын удирдлагатай харилцан зөвшилцж тохиролцсоны үндсэн дээр тус газрын байршилыг шилжүүлэн олгоход манай компанийн зүгээс татталзах зүйлүүг гэдгээ энэхүү албан тоотоор мэдэгдэж байна.



Март 28/02/2018  
Ганбямба  
М.Б

28.02.2018  
Ганбямба  
М.Б

## ЖИПЕЛ ХХК-ДАС ИРҮҮЛСЭН ТООТ




“ЖИПЕЛ” ХХК  
Чингис хот, Хэтийг аймаг  
Утас: 93-39-90-07

Азийн хөгжлийн банкинд

№ 2019 02 21  
танай 9/5 -ны № 18/01

Хэтийг аймгийн Хэрлэн сумын 5-р багийн нутаг дэвсгэрт байрлах хайрга чулуу бутлан агуулж, барилгын үйцдавчлал үйстчилгээний уйл ажиллагаа явуулдаг “Жипел” ХХК танай банкны Хэтийг аймгийн төмөрлэх байгууламж орсогтон тинччээх тослийг дэмжиж байна. Иймд манай компани газар чөлөөлж болох манай газар дээр байх 2 айлын оноходрийн амьдралын түвшини доржуулжгүй байх асуултыг манай компани хариуцин тус тослийн үйт ажиллагчанд ямар нийтэн саад болихгүй эзэр шийдвэртэй болно.



# ЖИПЕЛ ХХК-ААС ИРҮҮЛСЭН ХҮСЭЛТ

## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ТАНАА ХҮСЭЛТ ГАРГАХ НЬ

2018-02-07

Хэрлэн сумын б-р багийн нутаг дэвсгарт байрлах хайрга, чулuu бутлан анпилах, барилгын материал үйлдвэрлэх зориулалтадар "ЖИПЭЛ" ХХК нь 1 га газар азэмшидэг юм. Азийн Хөгжлийн Банкны төслийн аймгийн цэвэрлэх байгууламжийн өртөгтэл шинэчлэх болсон тул тус цэвэрлэх байгууламжийн хамгаалалтын бүсэд манай азэмшиж буй газар орсон байна. Иймд энэ газар манай оорийн хөрөнгөөр 40 метрийн гүнтэй гүний худаг 6000000 /Зургаан сая/ тогтолцоор ухуулсан тул энэ худгийн асуудлыг шийдэж вч туслана уу.



Хүсэлт гаргасан:

"ЖИПЭЛ" ХХК-ний захирал П.Дамдиндорж

## ЖИПЭЛ ХХК-ТАЙ УУЛЗАЛТ ХИЙСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2018.02.14

Хэрлэн сум

ЖИПЭЛ ХХК-тай хийсэн уулзалт хуралдаан Хэнтий аймгийн Засаг даргын орлогчийн өвөөнд хуралдаж, аймгийн Засаг даргын орлогч Ц.Чогсомжав хурлыг удисдан явуулав

Эхэлсэн цаг: 09 цаг 56 минут

Дууссан цаг: 10 цаг 46 минут

### Хуралд оролцсон

1. Ц.Чогсомжав /Аймгийн Засаг даргын орлогч/
2. Э.Менх-Ордэнэ /АЗДТГ, ХОХБТХ-ийн дарга/
3. С.Нямданаа /АЗДТГ, СТСХ-ийн дарга/
4. Ц.Бат-Эндэнэ /АЗДТГ, ХОХБТХ-ийн мэргэжилтэн/
5. Г.Дамдиндорж /ЖИ/ПЭЛ ХХК-ий захирал/
6. З.Урангоо /Харлэн сумын газрын үнамж/

### Хурлаар хэлэлцсэн асуудал

Цэвэрлэх байгууламжийн хамгаалалтын бусод байх Жипэл ХХК-ий зэмшилийн газрыг чөлөөлөх талаар

### Хурлаар хэлэлцсэн нь

Ц.Чогсомжав: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүртээ. Өнөөдөр цэвэрлэх байгууламжийн хамгаалалтын бусод байх Жипэл ХХК-ий зэмшилийн газрыг чөлөөлөх талаар хополцэн.

Хуралд оролцог-дын бүрэлдэхүүнийг танилцуулав.

Очигы омно Жипэл ХХК-ий захирал Г.Дамдиндорж танд Хэрлэн суманд баригдах цэвэрлэх байгууламжийн талаар тооч танилцуулья. Энэхүү цэвэрлэх байгууламж нь 3000м<sup>2</sup>-хоногт хүчин-чадалтай, Азийн хөгжлийн байкны санхүүжилтээр хэрагдаж байгаа төслийн ажлыг эхлээл явж байна. Одоо байгаа цэвэрлэх байгууламжийн картны хойд хэсэгт баригдахаар төлөвлөгөөд байна. Үүнтэй холбогдуултан аймгийн Иргэдийн Төвлөвлөгчдийн хурлаас 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолцор цэвэрлийн байгууламжийн хамгаалалтын бүсийг 1000 метрээр тогтоосон Ингээд хамгаалалтын бусад газар зэмшиж, ёмчилж байгаа иргэн М.Н, байгууллагуудтай харилцан тохиролцож газрыг чөлөөлөх арга хэмжээ зөвхөн ажиллаж байна. Тиймээс өнөөдөр таныг хүрэлцэн ирж харилцан тохиждож танай зэмшилийн газрыг чөлөөлөх чадлыг эврт хүссэн юм.

Танай компанийн зэмшиж байгаа газар Цэвэрлэх байгууламжийн хамгаалалтын бусод байгаан учраас зайлшгүй чөлөөлөх шаардлагатай байгаа. Орон

1

нутгийн зүгээс танай компанид цэвэрлэх байгууламжийн хамгаалалтын бүсийн гадна олгох нөхцөл санал болгож байна.

**3.Урангоо:** Хэрлэн сумын зүгээс Жипэл ХХК-д шинээр олгох газрын байршлыг тодорхой болгосон. Дамдиндорж гуайтай газар дээр нь очиж үзэж тохирсон байгаа. Газар эзэмшүүлэх шийдвэрийн төсөл боловсруулагдаад явж байна. Жипэл ХХК-д эзэмшүүлэхээр төлөвлөж байгаа газрын зураглал энд байна.

**П.Дамдиндорж:** Тиймээ Урангоо болон аймгийн ГХБХБГ-ын төлөөлөлтэй хамт манайд шинээр эзэмшүүлэх газрыг очиж үзэж, байршил дээр тохиролцсон байгаа. Орон нутгийн зүгээс тавьж байгаа саналыг хүлээж авьяа. Орон нутагт томоохон бүтээн байгуулалт хийгдэхээр ажил эхэлж байхад манай компанийн зүгээс одоо эзэмшиж байгаа газрыг чөлөөлөхөд татгалзах зүйл байхгүй. Харин манай гаргасан байгаа гүний худгийн нөхөн төлбөрт 6 сая төгрөгийг шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

**Ц.Чогсомжав:** Танай компаниас 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдөр аймгийн Засаг даргад гаргасан хүсэлттэй танилцсан. 40 метрийн гүнтэй гүний худгийн нөхөн төлбөрт 6 сая төгрөгийг шийдвэрлэж өгөхийг хүссэн байсан. Газар чөлөөлөхөд энэ гүний худгаас өөр орон нутагт тавьж шийдвэрлүүлэх хүсэлт бий юу?

**П.Дамдиндорж:** Өөр хүсэлт байхгүй ээ. Манай гүний худгийн нөхөн төлбөрт 6 сая төгрөгийг шийдвэрлээд өгчихвөл бусад газар чөлөөлөхөд гарах зардлыг манай компани хариуцна.

**С.Нямдаваа:** Гүний худгийн нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэхэд худгийн холбогдох бичиг баримт бүрэн байх ёстой, мөн аймгийн Засаг даргын шийдвэрээр шууд нөхөн төлбөр олгох боломжгүй аймгийн ИТХ-д уламжилж, шийдвэр гарсаны дараа олгох боломжтой.

**П.Дамдиндорж:** Худгийн бичиг баримт байгаа. ИТХ-ын шийдвэр гарах асуудлыг ойлгож байна аа.

**Ц.Чогсомжав:** За тэгвэл бид гүний худгийн нөхөн төлбөрийн асуудлыг аймгийн ИТХ-д шийдвэрлүүлэхээр уламжлах болно. Түүнээс гадна танай эзэмшлийн газар дээр өнөөдрийн байдлаар 2 айл амьдарч байгаа юм байна. Азийн хөгжлийн банкны зүгээс газар чөлөөлөлттэй холбоотойгоор айл өрхийн амьдралыг доройтуулахгүй байх бодлого баримталдаг. Тиймээс бид мөн энэ 2 айлын асуудлыг тантай зөвшилцэж зайлшгүй шийдвэрт хүрэх хэрэгтэй байна.

**П.Дамдиндорж:** Тийм ээ манай манаачийнх бий. Тэр 2 айлын өнөөдрийн амьдралын түвшин газар чөлөөлөлттэй холбоотойгоор дордохгүй байх, нүүхтэй холбогдох зардлыг манай компани хариуцна. Би баталгаа өгч байна. Тэр 2 айл шинээр манайд олгож байгаа газарт нүүж очоод бууна.

**Э.Мөнх-Эрдэнэ:** Шинээр олгосон газар 2 айл нүүж очоод амьдрахад цахилгаанд холбогдох боломжтой юу?

**П.Дамдиндорж:** Боломжтой. Тэр айлуудын өнөөдрийн амьдралын түвшин дордохгүй байх холбогдох асуудлыг манай компани хариуцъя аа.



**Ц.Чогсомжав:** Бид танайд шинээр эзэмшүүлэх газар болон гүний худгийн нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэж өгье. Газар чөлөөлөхтэй холбогдох зардал болон одоо танай эзэмшилийн газар дээр амьдарч байгаа 2 өрхийн өнөөдрийн амьдралын нөхцөлийг дордуулахгүй байхыг танай компани хариуцахаар шийдвэрт хүрлээ гэж ойлголоо. Та зөвшөөрч байна уу Дамдиндорж гуай?

**П.Дамдиндорж:** Би зөвшөөрч байна аа.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

**Орон нутгийн зүгээс:** ЖИПЭЛ ХХК-д шинээр эзэмшүүлэх газрын асуудлыг шийдвэрлэнэ. ЖИПЭЛ ХХК-ийн одоо эзэмшиж байгаа газар дээр гаргасан гүний худгийн нөхөн төлбөрийн асуудлыг аймгийн ИТХ-д шийдвэрлүүлэхээр уламжилна.

**ЖИПЭЛ ХХК нь:** Газар чөлөөлөхтэй холбогдох зардал болон одоо байгаа өөрийн эзэмшилийн газар дээр амьдарч байгаа 2 өрхийн өнөөдрийн амьдралын түвшин газар чөлөөлсний дараа дордохгүй байх холбогдох асуудлыг бүрэн хариуцна.

**Хурлын тэмдэглэл хөтөлсөн:**

АЗДТГ, ХОХБТХ-ийн мэргэжилтэн:


  
Ц.Бат-Эрдэнэ

**Хурлын тэмдэглэлтэй танилцаж баталгаажуулсан:**

Аймгийн Засаг даргын орлогч:

  
Ц.Чогсомжав

АЗДТГ, ХОХБТХ-ийн дарга:

  
Э.Мөнх-Эрдэнэ

АЗДТГ, СТСХ-ийн дарга:

  
С.Нямдаваа

ЖИПЭЛ ХХК-ийн захирал:

  
П.Дамдиндорж

Хэрлэн сумын газрын даамал:

  
З.Урангоо

# ХЭНТИЙ АЙМГИЙН ЗД-ИЙН ЗАХИРАМЖ



ХЭНТИЙ АЙМАГ  
ХЭРЛЭН СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 26 одoot

Удзэр 4/32.

Харлан сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
байршил шилжүүлэх тухай

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 23 дүгээр зүйлийн 29.2, 29.3 Иргэдээс төрийн байгууллага, албан тушавалтанд гаргасан өргөдөл томдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн төв Хэрлэн суманд цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн ажил хийгдэх төсөлт хэрэгжих болсонтой холбоотойгоор 5-р баг, Цэвэрлэх байгууламжийн зүүн талд үйлдвэрлэгийн зориулалтаар "Жилэл" ХХК-д зээмшигүүлсан 1.0 га газрын байршилыг шилжүүлэн 5-р баг, Элбэг баян говь ХХК-ны зуурмагийн үйлдвэрийн зүүн талд болгон өөрчилж 15 жилийн хугацаагаар эзэмшигүүлсүгэй.

2. Эзэмшил газрыг "Газрын тухай хуулийн дагуу эзэмших гэрчилгээ олгон гэрээ байгуулж ажиллахыг Газрын даамал 3.Урангоод зөвшөөрсүгэй.

3. Тус газрыг хуулийн дагуу зохистой, зориулалтаар нь эзэмшиж газрын төлбөрийг хугацаанд нь төлж гэрээг жил бүр дүнүүлж байхыг газар ААН-д даалгасугай.

ДАРГА  ЦИДЭРБАТ

05 000

## Хавсралт 5: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ЗД-ын тоотууд




67123, Морон, Хөвсгөл аймаг  
Утас, факс: 70384316

2018.01.02 № 8/б  
танай -ны № -т

### АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨСЛИЙН НЭГЖИД

Мөрөн сумын 13-р багт шинээр баригдах цэвэрлэх байгууламжийн хязгаарлалтын бүсэд нүүлгэн шилжүүлж, чөлөөлөх шаардлагатай иргэн хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газар байхгүй бөгөөд төсөл хэрэгжихэд газрын зөрчил маргаан үүсэхгүй болохыг үүгээр илэхийлж байна.



My/doc-2017

ЧБ-ЧЧ, 886 и<sup>2</sup>

МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 4829

Мөрөн

Газар эзэмших эрхийн гэрчилгээ  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, аймгийн ИТХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлэх хорин нэгэн аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Н.Бямбадорж/-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Г.Гандэлгэр/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Лхагвасүрэн/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

10-1398



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
МӨРӨН СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 12 сарын 25 өдөр


Дугаар 112-23

Мөрөн

Газар эзэмших эрхийн  
гэрчилгээ шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3, 38.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Газар эзэмших гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт ирүүлсэн нэр бүхий 2 аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийг хавсралтад заасны дагуу шилжүүлсүгэй.
- Дараах нэр бүхий иргэдийн газар эзэмших эрх олгосон захирамжуудын холбогдох заалтыг хүчингүй болгосугай.
- Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн төлбөр ногдуулалт хийж, баримт материалыг бүрдүүлэн гэрээ, гэрчилгээ олгохыг газрын даамал /Б.Батчулуунд/, хяналт тавихыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч /Э.Нямдаваа/-д тус тус үүрэг болгосугай.
- Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавихыг Засаг даргын орлогч /Б.Батбаяр/-д даалгасугай.



Zahiramj-Doc:A4-2017

100431

## Хавсралт 6: Сүхбаатар аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн тоо



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ  
ТӨСЛИЙН НЭГЖИД

СҮХБААТАР АЙМГИЙН  
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР  
22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг  
Утас, факс: 70518605, 70512605

2018. 01. 18 № 01/21  
танай -ны № -т

Хүсэлт хүргүүлэх тухай

Манай аймгийн төв Баруун-Урт хотын нь 2030 он хүртэл хөгжих хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2015 онд “Түмэд групп” ХХКомпани боловсруулан аймгийн ИТХурлын 2016 оны 04 тоот тогтоолоор батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Уг төлөвлөгөөнд хуучин цэвэрлэх байгууламжийг аймгийн төвөөс зүүн урд зүгт 965 метр шилжүүлэн шинээр барьж байгуулахаар Баруун-Урт сумын Засаг даргын 2016 оны А/124 тоот захирамжаар 6,8 га газрыг “Дөрвөлж” /ОНӨҮГ/ ХХКомпанид олгон зураг төслийг боловсруулан батлуулсан.

Дээрх зураг төсвөөр хийгдсэн шинэ цэвэрлэх байгууламж нь цаашид газар чөлөөлөлтөд орж нүүлгэн шилжүүлэх болон дахин төлөвлөлтөд орохгүйгээр урт хугацаанд ашиглагдахаас гадна хамгаалалтын бүсийг 500 метрээр тогтооход гэр хорооллын бустэй давхцал үүсэхгүйгээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан.

Иймд тус газраас хамгаалалтын бүсийг тогтоох асуудлыг 1 дүгээр улиралд багтаан аймгийн ИТХурлаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.



# Сүхбаатар аймгийн ЗД-ЫН ЗАХИРАМЖ



СҮХБААТАР АЙМГИЙН  
БАРУУН-УРТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2016 онд 06 сарын 20-ны өдөр

Дугаар 8/27

Баруун-Урт

Газар эзэмшиүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

Нэг Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу /000059419/ дугаарын улсын бүртгэлийн гэрчилгээтэй, /2016966/ регистрийн дугаартай "Дөрвөлж ОНӨААТҮГ" Газрын Нисэх буудлын зүүн талын бохир ус цэвэршуулэх байгууламжийг нүүлгэн шилжүүлэх болсонтой холбогдуулан Асгатын замын баруун талд, 7-р тойргийн замын урд цэвэрлэх байгууламжийн зориулалтаар 6,8 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшиүүлсүгэй.

Хоёр Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу газар эзэмших гэрээ байгуулан, эрхийн гэрчилгээ олгож, газрын хил заагийг тогтоож өгөхийг Хот төлөвлөлт, газар зохион байгуулалт хариуцсан мэргжилтэн /З.Мөнхбаяр/. Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга / Б.Амарзаяа / нарт үүрэг болгосугай.

Гурав. Эзэмшил газраа холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу эзэмшиж, гадна орчноо цэвэрхэн байлгах, тохижуулах, өнгө үзэмжийг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг "Дөрвөлж ОНӨААТҮГ" ХХК-д даалгасугай.

Дөрөв. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сүмүн засаг даргын 2015 оны 10-р сарын 19-ний өдрийн А/204 тоот захирамж, 306251 дугаартай гэрчилгээ, гэрээг хүчингүй болсонд тооцсугай.

М.ИДЭРБАТ

## Хавсралт 7: Гомдол гаргах маягт

Төсөл төслийн хэрэгжилттэй холбоотой гомдол, санал, асуулга, тайлбарыг хүлээн авна. Бид гомдол мэдүүлж байгаа этгээдээс нэр, холбоо барих мэдээллээ өгөхийг хүсдэг бөгөөд ийнхүү хийснээр бид тодруулах болон мэдээлэл өгөх зорилгоор тантай холбогдох боломжтой болно.

Та хувийн мэдээллээ оруулж болох бөгөөд хувийн мэдээллээ нууцлахыг хүсэх тохиолдолд дор дурдсан НУУЦЛАХ ШААРДЛАГАТАЙ нүдийг чагтална уу.

- Нууцлах шаардлагатай

### ГОМДЛЫН АНГИЛАЛ

- Хууль эрхзүй  Захиргаа  Нийгэмн  Санхүү  Техник  Байгаль орчин  Бусад

Огноо	Бүртгэсэн газар	Төсөл хэрэгжих талбай:
Нэр (нууц биш бол)		
Гэрийн хаяг		
Баг		
Утасны дугаар/и-мэйл:		
Гомдол/тайлбар эсвэл саналын дэлгэрэнгүй:		
Хэрэв хавсралт/санамж/ албан захидал оруулсан бол энэ нүдийг чагтална уу:	<input type="checkbox"/>	

### ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАНА

Бүртгэсэн: (Гомдлыг бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг)

Харилцаа холбооны хэлбэр:

Санамж/Албан захидал

И-мэйл

Амаар/

Хянасан: (Гомдлыг хянасан ажилтны нэр/албан тушаал)

Авсан арга хэмжээ:

Авсан арга хэмжээг танилцуулсан эсэх :  Тийм  Үгүй

Танилцуулсан хэлбэр:

## Хавсралт 8: ГЧНШТ-ний төлөвлөлтийн үед хийгдсэн уулзалтууд

<b>Сар өдөр</b>	<b>Хаана</b>	<b>Нэр</b>
12/19, 12/22 01/24	Булган аймаг	Д. Очирбат, Булган Мээж ХХК-ний Захирал Г. Энхтайван, Булган Мээж ХХК-ний бохирын инженер Н. Нармандах, Булган Мээж ХХК-ний нябо
12/20 01/24	Булган аймаг	Д. Батзориг, Булган аймгийн ЗД Н. Бямбасүрэн, ГХБХБГ-ын дарга Б. Ганзориг, Булган аймгийн Ерөнхий архитекторч С. Наранбаатар, ГХБХБГ-ын Газрын удирдлагын хэлтсийн дарга Р. Гүржав, ГХБХБГ-ын барилга хариуцсан мэргэжилтэн Г. Батцагаан, ГХБХБГ-ын НААҮГ хариуцсан мэргэжилтэн Д. Наранбаяр, Булган сумын ЗД Б. Цолмон, Булган сумын газрын даамал Д. Буманбаяр, Хөрөнгө оруулалт, хөгжлийн хэлтсийн дарга А. Гантэмэр, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Ц. Бүрэнтуяа, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б. Оюунбат, Булган сумын ЗД Б. Долгорсүрэн, МХГ-ын дарга Б. Сээр-Од, Булган аймгийн зөвлөх инженер О. Ихбаяр, Булган аймгийн захиргааны хэлтсийн дарга Г. Гантулга, ГХБХБГ-ын хөгжил хариуцсан мэргэжилтэн Г. Отгонбаяр, Цахилгаан түгээх газрын ахлах инженер
12/21	Хөвсгөл аймаг	Л. Ганболд, Хөвсгөл аймгийн ЗД Ц. Баттогтох, Хөвсгөл аймгийн ЗД-ын орлогч Г. Энхбаяр, Хөвсгөл-Ус Суваг ХХК-ний Гүйцэтгэх захирал Д. Сүхээ, Хөвсгөл-Ус Суваг ХХК-ний Ерөнхий инженер Л. Болормаа, Хөвсгөл-Ус Суваг ХХК-ний эдийн засагч У. Ариунаа, Хөвсгөл-Ус Суваг ХХК-ний дулааны ахлах инженер Н. Бямбадорж, ГХБХБГ-ын дарга Д. Мягмарсүрэн, Хөвсгөл аймгийн МХГ-ын ахлах мэргэжилтэн Н. Нямбат, ГХБХБГ-ын инженерийн шугам сүлжээ хариуцсан мэргэжилтэн П. Цэндэнжаргал, Дулааны сүлжээний хэлтсийн инженер Б. Батбаяр, Мөрөн сумын ЗД-ын орлогч, Б. Шинэбаяр, Стандарт, хэмжил зүйн газрын мэргэжилтэн Б. Даваасүрэн, МХГ-ын улсын байцаагч н. Аззаяа, Хөвсгөл аймгийн Ерөнхий архитекторч
12/27, 12/28 01/21	Дундговь аймаг	Д. Ганбаатар, Дундговь-Ус ОНӨҮГ-ын дарга Ч. Баяrbат, Дундговь-Ус ОНӨҮГ-ын Ерөнхий инженер Б. Уламбаяр, Дундговь-Ус ОНӨҮГ-ын ашиглалтын инженер Л. Сүрэндолгор, Дундговь-Ус ОНӨҮГ-ын Ерөнхий нябо
12/28 01/21	Дундговь аймаг	О. Бат-Эрдэнэ, Дундговь аймгийн Засаг дарга Ж. Мөнхчулуун, Дундговь аймгийн ЗД-ын орлогч Н. Эрдэнэ-Очир, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс Н. Гантулга, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Д. Нэргүй, ГХБХБГ-ын барилгын хэлтсийн дарга Б. Ренчиндорж, ГХБХБГ-ын газрын удирдлагын хэлтсийн дарга Б. Ганбат, Дундговь аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С. Ууганбаяр, Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга н. Оюунчимэг, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын улсын байцаагч н. Мөнхзуул, ЗДТГ-ын өрөнгө оруулалт, хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн
01/15 01/16	Хэнтий аймаг	Н. Ганбяма, Хэнтий аймгийн Засаг дарга Г. Хэрлэнчулзуун, Хэнтий аймгийн ЗД-ын орлогч Э. Мөнх-Эрдэнэ, Хөрөнгө оруулалт, хөгжлийн хэлтсийн дарга Д. Баярхүү, ГХБХБГ-ын дарга Х. Ганчлууун, Цахилгаан Түгээх газрын дарга н. Дархантуул, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга н. Сүмбээ, Хэнтий аймгийн МХГ-ын дарга

		Ц. Идэрбат, Хэрлэн сумын Засаг дарга Н.Мөнхжаргал, Хэрлэн сумын Ерөнхий архитекторч н.Урангоо, Хэрлэн сумын газрын даамал Г. Батгэрэл, Хэнтий-Ус ХХК-ны дарга Д. Дарханбаяр, Хэнтий-Ус ХХК-ны Ерөнхий инженер Б. Бямбасүх, Хэнтий-Ус ХХК-ны ашиглалт хариуцсан инженер Д. Эрдэнэбат, Хэнтий-Ус ХХК-ны Ерөнхий нябо
02/13		Ц. Чогсомжав, Нийгмийн асуудал хариуцсан ЗД-ын орлогч н.Билэгсайхан, ГХБХБГ-ын кадастрын мэргэжилтэн Ц. Бат-Эрдэнэ, Хөрөнгө оруулалт, хөгжлийн газрын дарга Д. Дарханбаяр, Хэнтий-Ус ХХК-ны Ерөнхий инженер Б. Бямбасүх, Хэнтий-Ус ХХК-ны ашиглалт хариуцсан инженер Д. Энхбаатар, оршин суугч Э. Сэмпин, оршин суугч
01/17	Сүхбаатар аймаг	З. Энхтөр, Сүхбаатар аймгийн Засаг дарга
01/18		Т. Амарбаатар, ЗД-ын орлогч Ц. Амарзаяа, Хөрөнгө оруулалт, хөгжлийн газрын дарга Х. Хишигбадрах, ГХБХБГ-ын дарга Ж. Батмуурь, Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн М. Төмөрчулуун, Төрийн сангийн хэлтсийн дарга Б. Мөнхтуяа, Төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн  О. Дүүрэнбилэг, Дөрвөлж ХХК-ний захирал /НААУГ/ Ч. Алдарбат, Дөрвөлж ХХК-ний Ерөнхий инженер Г. Наранцэцэг, Дөрвөлж ХХК-ний Ерөнхий нябо Б. Лантуу, Дөрвөлж ХХК-ний зөвлөх Б. Буджав, Дөрвөлж ХХК-ний усны инженер

## **Хавсралт 9: Газар чөлөөлөлтийн тухай товхимол**

**SC 109894 MON: Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн Нэмэлтийн нэмэлт санхүүжилтийн бэлтгэл төсөл**

### **Газар чөлөөлөлтийн тухай товхимол**

**40. Хэнтий аймгийн дэд төслийн хүрээ.** Дэд төслийн хүрээнд шинээр ЦБ барих, одоогийн насос станцыг өргөтгөх болон бусад ажлууд хийгдэнэ.

**41. Хэрэглээний болон бохир усны үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагааг хариуцах, нийтийн аж ахуйн үйлчилгээг иргэдэд үзүүлэх байгууллага нь Хэнтий-Ус ХХК юм.**

**42. Албадан газар чөлөөлөлтийн нөлөөллийг тодорхойлох, зөвлөлдөх уулзалтууд.** Төслийн ажлын үеэр газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ямар нэгэн нөлөөлөл гарах эсэхийг тодруулахаар төслийн багийн гишүүд, Хэнтий-Ус ХХК-ний дарга, инженер, орон нутгийн холбогдох албаны хүмүүстэй хамт газар дээр 2017 оны 12-р сар болон 2018 оны 1-р сард нийт 2 удаа нь ажиллав.

- a. **Шинэ ЦБ:** Шинэ ЦБ-ыг одоогийн цэвэрлэх байгууламжийн баруун хойд талд байгуулахаар зураг төсөл нь хийгдсэн. Цэвэрлэх байгууламжид 2018 оны 03-р сарын 01-нд аймгийн Засаг даргын А/83 тоот захирамжаар нийт 150671м<sup>2</sup> газрыг 47 жилийн хугацаатайгаар олгосон.
- b. **Хамгаалах бүс:** 2018 оны 02-р сарын 07-ны ИТХ-ын 7-р хуралдааны 2-р хурлаар хамгаалах бүсийг 100м-ээр тогтоосон.
- c. **Насос станц:** Нийт талбай нь 200м<sup>2</sup>. Хэрлэн сумын 4-р багийн нутаг дэвсгэрт оршдог энэхүү газар нь Хэнтий-Ус ХХК-ний эзэмшлийн газар юм.
- d. **Цахилгаан болон дулаан хангамж:** Шинэ ЦБ-ын цахилгаан болон дулаан хангамжийг одоогийн байгаа сүлжээнээс авахаар төлөвлөсөн.
- e. **Усан хангамж:** ЦБ-ын усан хангамжийг дотроо гүний худгаар шийдэгдэнэ.

**43. ГЧНШ-ийн нөлөөллийн хүрээ.** Дэд төслийн нөлөөлөлд өртөх 2 НӨИ байна.

- a. **Шинэ ЦБ.** Одоогийн цэвэрлэх байгууламжийн зүүн талд орших СЕКТЭК ХХК-ний эзэмшлийн газраас хэсэг газар нь ЦБ-д шинээр олгох газартай давхцаж байгаа. Тус компани нь төлөвлөгдөж буй ЦБ-ын зүүн талд нийтдээ 16,003 м<sup>2</sup> газар эзэмшдэг бөгөөд газар дээр ямар нэгэн барилга, байгууламж байхгүй.
- b. **Хамгаалах бүс.** “Жипел” ХХ компанийн нэр дээрх эзэмшлийн газар дээр байгаа бутлуурын үйлдвэр нөлөөлөлд өртөнө. Бутлуурын үйлдвэр нь улирлын чанартай ажлаа явуулдаг. Өөрийн хөрөнгөөр 40м-т гүний худаг гаргуулсан. Компанийн манаач эмэгтэйн гэр бүл компанийн газар дээр, гэрт амьдардаг.

**44. Зорилго, хууль болон бодлогын хамрах хүрээ нь АХБ-ны Нийгмийн хамгааллын Бодлогын баримт бичгийн дагуу хийгдсэн бөгөөд нөлөөлөлд өртсөн иргэд зохих туслалцаа, нөхөн олговор авсан эсэх, иргэдийн амьжиргааг наад зах нь төслийн өмнөх**

үеэс дордуулахгүй хэвээр хадгалахын тулд төслийн төлөвлөлтөнд оролцуулах боломжоор хангахад чиглэсэн туслалцааг үзүүлнэ гэсэн үг юм. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нөлөөлөлд өртөгчдийг төслийн талаарх мэдээллээр хангах, ойр дотно зөвлөлдөх, учирсан хохирлыг нь нөхөн олгох, орлуулах газар, өмч хөрөнгийг эзэмших, өмчлөхөд туслалцаа үзүүлнэ.

45. Энэхүү ГЧНШТ-ний бүх заалт нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, АХБ-ны 2009 оны Нийгмийн хамгааллын бодлогын баримт бичиг (НХБББ)-ийн дагуу байна. Үндэсний хууль тогтоомжид МУ-ын Үндсэн хууль, Газрын тухай хууль, МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Иргэний хууль багтана.

46. АХБ-ны НХБББ-ийн дагуу “Туслалцаа авах эрхийг тасалбар болгох өдөр”-өөс өмнө оршин сууж байсан бүх нөлөөлөлд өртсөн өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, хууль ёсны оршин суугч, зөвшөөрөлгүй иргэн болон түрээслэгчид туслалцаа авах эрхтэй. Нөлөөлөлд өртсөн газар, өмч хөрөнгөнд нөхөн олговор олгоходо орлуулах үнийн зарчмаар тооцно

47. Төслийг албан ёсоор зарласан, төслийн байршил тодорхой болсон, нөлөөлөлд өртөгчдийн тооллого судалгааг хийсний дараа газрын наймаа, зөвшөөрөлгүй иргэдийн хэт урсгалаас урьдчилан сэргийлэхийн тулд “Туслалцаа авах эрхийг тасалбар болгох өдөр”-ийг тогтооно. Энэ төслийн тухайд төслийн байршилд тодорхой болсон ба компаниудад хурал хийх, захидал илгээх байдлаар албан ёсны мэдэгдэл хүргүүлсэн болно.

#### **Хүснэгт: Туслалцаа авах эрх ба авах туслалцаа**

<b>Хохирлын төрөл</b>	<b>Туслалцаа авах эрхтэй иргэд</b>	<b>Авах нөхөн олговор, туслалцаа</b>
Газар ( Эзэмшсэн газар)	2 хувийн компани: СЭКТЕК Групп ХХК Жипел ХХК	Энэ 2 компанид газрыг газраар нөхөн олгоно.  Жипел ХХК-ний хувьд, эмэгтэй манаачийн гэр бүл болон хажууд нь хамт амьдардаг түүний охины гэр бүлийг Засгийн газраас олгох шинэ байршилд нүүлгэх ажлыг хариуцна. Эдгээр гэр бүлүүдэд шаардлагатай аливаа зардал, тусlamжийг тухайн компани хариуцна <sup>7</sup> .
Нөлөөлөлд өртсөн гүний худаг	Жипел ХХК	Орлуулах үнийн зарчмаар бэлэн мөнгөний нөхөн олговор олгоно. Элэгдэл хорогдол тооцохгүй.
Урьдчилж харах боломжгүй нөлөөлөл	Тодорхойгүй	Төслийн хэрэгжилтийн явцад учрах, урьдчилан харах боломжгүй байсан нөлөөлөл; Энэ тохиолдолд АХБ-ны бодлогын дагуу тохирох арга хэмжээг авч, хэрэгжүүлэхээс өмнө АХБ-д тайлagnана.
Нөлөөлөлд өртсөн байгууламж	Барилга, байгууламж өмчлөгч (тодорхойгүй)	Төслийн хэрэгжилтийн явцад ямар нэгэн барилга байгууламж нөлөөлөлд өртөхөөр бол нөхөн олговрыг орлуулах үнийн зарчмаар тухайн үеийн зах зээлийн ханшаар, элэгдэл хорогдол тооцохгүй олгоно. Мөн ажлын хөлс, тээврийн зардлыг олгоно. Мөн аварч болох материалын үнийг нөхөн олговоос суутгахгүй.

<sup>7</sup> Эдгээр өрхөд туслалцаа үзүүлэх, амьжиргааг нь дордуулахгүй байхад анхаарна гэдгээ Жипел ХХК мэдэгдсэн ба энэ талаар хурлын тэмдэглэлд дурьдсан.

**48. Гомдол барагдуулалт.** НААУБ тус бүр төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой (байнгын болон түр нөлөөлөл, газар ашиглах эрхийг хязгаарласан) нөлөөлөлд өртсөн иргэн/байгууллагаас гаргасан аливаа гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, баримтжуулах ажилтаныг томилно.

**49. Хэрэгжүүлэх арга зам.** БХБЯ нь нэмэлт санхүүжилтийн төслийн гүйцэтгэх ба хэрэгжүүлэгч агентлаг нь бөгөөд одоо байгаа ТҮН-ээр дамжуулан чиг үүргээ хэрэгжүүлнэ. ТҮН нь энэхүү төслийн улмаас үүрэг хариуцлагаа өргөжүүлнэ.

50. Аймгийн түвшинд, төслийн хяналтыг НААУБ-аас томилогдсон хагас цагаар ажиллах ажилтанаас бүрдэх дэмжих нэгжээр дамжуулан хэрэгжүүлнэ. ТҮН-д зээлийн төслийн хүрээнд хөлсөөр ажиллах зөвлөхүүдийн тусламжтайгаар төслийн удирдлага, хэрэгжилтэнд туслалцаа үзүүлнэ. Төслийн удирдлага, хэрэгжилтийг дэмжих зөвлөх нь төслийн удирдлага, худалдан авалт, хяналт, нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилт болон мониторингийн чиглэлээр ТҮН, НААУБ-ийн дэмжих нэгжид туслалцаа үзүүлнэ

**51. Хэрэгжилтийн хуваарь ба Мониторинг.** Төсөл хэрэгжүүлэх хугацаа 2018 оны 7-р сараас 2021 оны 12-р сар хүртэл байна. Хэрэгжилтийн явцад зураг төсөлд ямар нэгэн өөрчлөлт гарч ГЧНШ-ийн нөлөөлөлд өөрчлөлт орох эсхүл шинээр нөлөөлөл учирвал, энэхүү ГЧНШТ-ийг шинэчилж, газар чөлөөлөлт хийхээс өмнө АХБ-д батлуулахаар хүргүүлнэ.

52. Барилгын ажил эхлэхээс өмнө ТҮН нь ГЧНШ-ийн хэрэгжилтийн талаар тайлagnана. Ялангуяа, цаг тухайд нь нөлөөлөлд өртсөн 2 компанийд газар олгох, гүний худагт нөхөн олговор олгосон байна.

53. Нөхөн олговор олгох, нүүх ажиллагаа бүрэн дуусаагүй тохиолдолд барилгын ажлыг эхлүүлэхгүй.

54. ТҮН нь ГЧНШ-ийн хэрэгжилтийг хянана. Төслийн хагас жилийн тайланд ГЧНШ-ийн хэрэгжилтийн тухай нэг хэсэг оруулна. Үүнд хийгдсэн зөвлөлдөх уулзалтууд, иргэдээс гаргасан гомдол, тэдгээрийг хэрхэн шийдсэн тухай, шинээр газар олгосон эсэх, нөхөн олговрыг олгосон эсэх, Жипел компанийн эмэгтэй манаачийн гэр бүлд үзүүлсэн туслалцаа зэрэг мэдээллийг багтаасан байна.